

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал нарын 20 гишүүнээс 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд малын тоо хурдацтай нэмэгдэж, нүүдлийн мал аж ахуйг эрхлэх явцад хүрээлэн буй орчин, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх асуудал орхигдож, нүүдлийн мал аж ахуйн уламжлал, заншлын хэм хэмжээний нөлөө буурч байна. Иймд бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах, дорийтлоос сэргийлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар хууль санаачлагчид уг хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлогт тохируулан бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд тулгуурлан ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах боломж бурдэнэ гэж үзэн хууль санаачлагчид төслийг боловсруулан, d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан төслийг дэмжиж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ бэлчээрийн асуудал зөвхөн малчдын бус сум аймаг, хот суурин төдийгүй Монгол Улсын тулгамдсан асуудал болж байгааг тэмдэглээд, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортод төрийн бодлого, дэмжлэг шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, махны экспортыг тогтвортой явуулах, бэлчээрийн даац, малын тоо, толгойг зүй зохистой болгох, бэлчээрийг хамгаалах зөв менежмент явуулах, хуулийг зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох зэрэг асуудлыг төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун хуулийн төслийн зохицуулалт хэт ерөнхий байгааг дурдаад худаг, уст цэг гаргах зэрэг зарим тулгамдсан асуудлыг хэлэлцүүлгийн явцад нарийвчлан зохицуулах шаардлагатай талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон

гишүүдийн олонх буюу 57.1 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

TYC3764 9023051393 9087184